



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Мэд оны 09 сарын 26 өдөр

Дугаар 886

Номгон

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 2 дахь заалт, 2021 оны 374 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нутгийн Захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагад мөрдөгдөж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаа, ил тод байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг журамд заасан хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж байхыг сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, орон нутгийн өмчит байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3. Сум, агентлаг, аймгийн Засаг даргын Тамгын газрын нэгж, орон нутгийн өмчит байгууллагын Бодлогын баримт бичиг болон Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа, ил тод байдлын хэрэгжилтэд жил бүр хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гарсан дүн, ахиц өөрчлөлт, цаашид авах арга хэмжээний талаар тайлагнах, хариуцлагагүй хандсан сумдын Засаг дарга, хэлтэс, агентлаг, орон нутгийн өмчит байгууллагын захирал, дарга нарт хариуцлага тооцуулах асуудлыг Засаг даргын зөвлөлд тухай бүр танилцуулж байхыг Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Л.Мандал-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхжаргал-д даалгасугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 26-ний өдрийн А/142 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын
26 -ны...өдрийн... дугаар захирамжийн хавсралт

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, НУТГИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ОРОН
НУТГИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөгжлийн бодлогын баримт бичиг (цаашид “бодлогын баримт бичиг” гэх), хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Журмын 1.1-т заасан байгууллагыг дараах байдлаар ойлгоно.

1.2.1. Нутгийн захиргааны байгууллага гэдэгт аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар;

1.2.2. Орон нутгийн өмчийн байгууллагад аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор байгуулагдсан байгууллага хамаарах бөгөөд босоо чиг үүрэг бүхий төсөвт байгууллагуудыг орон нутгийн өмчийн байгууллагатай адилтган үнэлнэ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, зорилт

2.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төрийн болон орон нутгийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилт:

2.2.1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр нь хүлээж буй үр дүнд хүрч хэрэгжиж байгаа эсэхийг тогтоох;

2.2.2. Хэлтэс, агентлаг, байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх;

2.2.3. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл

ажиллагаанд гарч буй ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, зөрчил дутагдлыг засч залруулах;

2.2.4. Шийдвэр гаргах үйл ажиллагааг бодит байдал, нотлох баримтад тулгуурласан байхад чиглүүлэх болон бодлогын хувилбар, санал, дүгнэлт, зөвлөмжөөр хангах;

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим,
хамрах хүрээ:**

3.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дараах зарчмыг баримтална.

3.1.1. Шударга, хараат бус байх;

3.1.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлт ил тод байх;

3.1.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

3.1.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан дүгнэлт нь тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх;

3.1.5. Хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;

3.1.6. Хяналт-шинжилгээ үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч болон олон нийтийн оролцоог хангасан байх;

3.1.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайландаа тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг холбогдох нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллага, албан тушаалтан хариуцдаг байх;

3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд дараах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагаа багтана.

3.2.1. Бодлогын баримт бичигт дараах бичиг баримт хамаарна.

3.2.1.1.“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;

3.2.1.2.Хөгжлийн зорилтот хөтөлбөр;

3.2.1.3.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;

3.2.1.4.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хамт);

3.2.1.5.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө;

3.2.1.6.Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;

3.2.1.7.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хамт);

3.2.1.8.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө;

3.2.1.9.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хамт);

3.2.1.10.Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө;

3.2.1.11.Хуульд нийцүүлэн хүчингүй болсонд тооцсон болон хугацаа дууссан бодлогын баримт бичгийн тайлан;

3.2.2. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт дараах баримт бичгүүд хамаарна.

3.2.2.1.Монгол Улсын хууль;

3.2.2.2.Улсын Их хурлын тогтоол;

3.2.2.3.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол;

3.2.2.4.Ерөнхийлөгчийн зарлиг;

3.2.2.5.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр;

3.2.2.6.Засгийн газрын тогтоол;

3.2.2.7.Ерөнхий сайдын захирамж;

3.2.2.8.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл;

3.2.2.9.Засгийн газрын болон Ерөнхий сайдын албан даалгавар;

3.2.2.10.Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол;

3.2.2.11.Аймгийн Засаг даргын захирамж;

3.2.2.12.Аймгийн Засаг даргын албан даалгавар, Засаг даргын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг, даалгавар;

3.2.2.13.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмж;

3.2.3. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд дараах бичиг баримт, үйл ажиллагаа хамаарна.

3.2.3.1.Стратеги төлөвлөгөө;

3.2.3.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө;

3.2.3.3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр;

3.2.3.4.Шилэн дансны хөтлөлт;

3.2.3.5.Байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;

3.2.3.6. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;

3.2.3.7. Аймгийн Засаг даргатай сум, агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын захирал, дарга нарын байгуулсан гэрээний хэрэгжилт;

3.2.3.8. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт;

3.2.3.9. Агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт;

3.2.3.10. Тухайн жилд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт;

3.2.3.11. Архив, албан хэрэг хөтлөлт;

3.2.3.12. Хэрэглэгчийн үнэлгээ;

3.2.3.13. Гадаадын зээл, тусlamжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт;

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, зохион байгуулалт, эрх, үүрэг:

4.1. Нутгийн захиргааны байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг болон сумын Засаг даргын Тамгын газар нь харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалтай байж болно.

4.2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлыг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна.

4.3. Нутгийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, хүний нөөцийн чадавхыг сайжруулах асуудлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс зохион байгуулна.

4.4. Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл-

ажиллагааны тайланг нэгтгэн дүнг ирүүлэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

4.5. Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй.

4.6. Бодлогын баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шатанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан, нэгжээс төлөөлөл оруулан хамтран ажиллана.

4.7. Тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж байгууллагын чиг үүрэг, бүтэц, орон тооны хязгаарт нийцсэн үйл ажиллагаа явуулахад хүрэлцэхүйц бүрэлдэхүүнтэй байна.

4.8. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь дараах бүрэн эрхтэй.

4.8.1. Байгууллагын дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцах, хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээлэл, баримт, материалыг холбогдох нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

4.8.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр зөвлөмж өгөх, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд гаргах;

4.8.3. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

4.9.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь дараах үүрэгтэй байна.

4.9.1. Хууль тогтоомж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах;

4.9.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад олж авсан баримт, мэдээллийн нууцыг чанд хадгалж зөвхөн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд ашиглах;

4.9.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах;

4.9.4.Тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгах;

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл, тайлагнах арга зүй:

5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл.

5.1.1. Нутгийн захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг батална. Энэхүү төлөвлөгөө нь тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн төлөвлөгөө байж болно. Төлөвлөгөөнд зорилго, хамрагдах байгууллага, нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал, хамтран оролцох байгууллага зэргийг тусгана.

5.1.2. Нутгийн захиргааны байгууллага нь үнэлгээний зорилгоос хамааруулан үр дүнд суурилсан явцын болон эцсийн үнэлгээ хийх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд ямар төрлийн үнэлгээ хийх талаар нарийвчлан тусгана.

5.1.3. Хөндлөнгийн үнэлгээг явцын болон эцсийн үнэлгээний аль ч шатанд хийж болох бөгөөд иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

5.2. Бодлогын зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайлан дараах шаардлагыг хангасан байна.

5.2.1. Нэг зүйл, заалт, бодлогын зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг товч, тодорхой, 2000 тэмдэгтэд багтааж тайлагнана.

5.2.2. Тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой тайлагнах, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийг тодорхой дурдах;

5.3. Бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй:

5.3.1. Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараах аргачлалын дагуу хувиар илэрхийлэн үнэлнэ.

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} * 100\%$$

5.3.2. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараах аргачлалаар тооцно.

5.3.2.1. Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь;

5.3.2.2. Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны

байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь;

5.3.2.3. Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь;

5.3.2.4. Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30 хувь;

5.3.2.5. Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхдэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг “0” хувь.

5.3.3. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг энэ журмын 5.3.1, 5.3.2-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцно.

5.3.3.1. “**үр дүнтэй**” - зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь;

5.3.3.2. “**тодорхой үр дүнд хүрсэн**” - зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-100 хүртэл хувь;

5.3.3.3. “**эрчимжүүлэх шаардлагатай**” - зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 30-70 хүртэл хувь;

5.3.3.4. “**үр дүнгүй**” - зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0-30 хүртэл хувь;

5.4. Бодлогын зорилт, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлт, тайлагналт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх арга зүй:

Нэг зорилт, арга хэмжээний хувьд:

5.4.1. “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-ийн 5 дугаар зүйл (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, баримтлах зарчим)-д

нийцүүлэн төлөвлөөгүй бол сул төлөвлөлт гэж үзэн хэрэгжилтийн үнэлгээг 20 хувиар бууруулна.

5.4.2. Тайланд тавигдах шаардлагад нийцүүлэн тайлагнаагүй бол тайлангийн чанар мую гэж үзэн хэрэгжилтийн үнэлгээг 20 хувиар бууруулна.

5.4.3. Дээрх хоёр алдаа нэг зорилт, арга хэмжээний төлөвлөлт, тайлагналт дээр зэрэг гарсан бол хэрэгжилтийн үнэлгээг 20 хувиар бууруулна.

5.4.4. Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоолоор баталсан журмууд, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 тоот тушаалаар баталсан аргачлалын дагуу байгууллага, нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлээгүй бол хэрэгжилтийн үнэлгээг 20 хувиар бууруулна.

5.4.5. Тухайн бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг шууд уялдаатай хөгжлийн үзүүлэлтийн өөрчлөлттэй харьцуулан 20 хувиар өсгөж, бууруулж болно.

5.4.6. Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хучин зүйлийн улмаас хэрэгжүүлэх боломжгүй болсон бол хэрэгжилтийг үнэлэхгүй байж болно.

Нэг бодлогын баримт бичгийн хувьд:

5.4.7. Баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа хугацаа хоцроосон бол тухайн байгууллагын жилийн үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг 20 хувиар бууруулна.

5.4.8. Баримт бичгийн хэрэгжилтийн тайланд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулаагүй бол тухайн байгууллагын тайланг хүчингүйд тооцно.

5.4.9. Тухайн баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг шууд уялдаатай хөгжлийн үзүүлэлтүүдийн дараах эх үүсвэртэй харьцуулан үнэлнэ. Үүнд:

5.4.9.1. Албан ёсны болон захиргааны статистик мэдээллийн өөрчлөлт;

5.4.9.2. Орон нутгийн болон сумын хөгжлийн индексийн өөрчлөлт;

5.4.9.3. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;

5.5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх арга зүй:

5.5.1. “Бүрэн хэрэгжсэн” - холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

5.5.2. “Хэрэгжих шатанд” - тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-90 хүртэл хувь);

5.5.3. “Хэрэгжилт хангалтгүй” - тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-50 хүртэл хувь);

5.5.4. “Хэрэгжээгүй” - тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-10 хүртэл хувь);

5.5.5. “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”.

5.6. Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн өрөнхий дүнг гаргахдаа зорилт, арга хэмжээ, зүйл, заалт бүрийн хэрэгжилтийн арифметик дунджаар тооцно.

5.7. Аймгийн Засаг даргын Тамгын газрын нэгж, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, орон нутгийн өмчийн байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газрын тухайн жилийн үйл ажиллагааны үнэлгээний дүнг гаргахдаа үзүүлэлт бүрийн үнэлгээг 100 хүртэл хувиар илэрхийлэн нийлбэр үнэлгээний арифметик дунджийг харгалзах жинд шилжүүлнэ. Ерөнхий үнэлгээг тодорхойлохдоо жинд шилжүүлсэн дүнгүүдийн нийлбэрийг 0.05-аар үржүүлж, 0-5 хүртэл оноонд шилжүүлэн дүгнэнэ.

5.8.Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хоёр удаагийн тайлангийн хугацаанд дараалан ахиц гараагүй бол удааширсан, гурван удаагийн тайлангийн хугацаанд ахиц гараагүй бол тасарсанд тооцно.

5.9.Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, аймгийн Засаг даргатай агентлагийн дарга, сумын Засаг дарга, орон нутгийн өмчийн байгууллагын удирдлагатай байгуулсан гэрээний хэрэгжилт, стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалаар, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмж, байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалаар тус тус тооцож үнэлнэ.

5.10.Хяналт-шинжилгээ үнэлгээний нэгж илрүүлсэн зөрчил дутагдлыг засаж залруулах буюу үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах талаар байгууллагын холбогдох албан тушаалтанд зөвлөмж өгч хэрэгжилтийг хангулна.

**Зургаа. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх:**

6.1. Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дараах үе шатаар цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

- 6.1.1. Мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх;
- 6.1.2. Зорилтын биелэлтийн дүнг үнэлэх;
- 6.1.3. Биелэлтийн түвшинг үнэлэх;
- 6.1.4. Биелэлтийн үр нөлөөг үнэлэх;
- 6.1.5. Гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх;
- 6.1.6. Төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх;

6.2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу энэ журмын 5.3; 5.4; 5.5-т заасан аргачлалаар үнэлнэ.

6.3. Шаардлагатай тохиолдолд харьяалах дээд шатны байгууллага нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, тайланг хэлэлцэн түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авна.

6.4. Энэ журмын 3.2.1-т заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн тайланг журмын 2;3;4;5; 9 дүгээр хавсралтын дагуу гаргаж, журмын 1 дүгээр хавсралтын дагуу холбогдох байгууллага, бүтцийн нэгжид хүргүүлнэ.

**Долоо. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн
хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх:**

7.1. Нутгийн захиргааны байгууллага нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтийг салбар, чиглэлээр ангилан энэ журмын 7, 8 дугаар хавсралтын дагуу гаргаж, тайланг энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу харьяалах дээд шатны байгууллага, бүтцийн нэгжид хүргүүлнэ.

7.2. Нутгийн захиргааны байгууллагад өгсөн үүргийн хэрэгжилтийг шийдвэрийн эхэнд бичигдсэн аймгийн Засаг даргын Тамгын газрын нэгж, агентлагийн дарга, сумын Засаг дарга, ажлын хэсгийн ахлагч нэгтгэн мэдээлнэ.

7.3. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, тэдгээрт нийцүүлэн гаргасан шийдвэрийн биелэлтийг нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллага хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах бөгөөд хэрэгжилтэд нь

холбогдох төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллана.

7.4. Нутгийн захиргааны байгууллага бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон сүүлийн 3 жил тасарсан болон тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтыг хүчингүй болгох, хяналтаас хасах тухай саналыг жилийн эцсийн тайлангийн хамт дээд шатны байгууллагад хүргүүлнэ. Хуульд нийцүүлэн хүчингүй болсонд тооцсон болон хугацаа дууссан бодлогын баримт бичгийн тайланг энэ журмын 6 дугаар хавсралтын дагуу гаргаж, энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу холбогдох байгууллага, бүтцийн нэгжид хүргүүлнэ.

7.5. Шаардлагатай гэж үзвэл дээд шатны байгууллага нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, тайлан, мэдээллийг хэлэлцэн тэдгээрийн мөрөөр холбогдох арга хэмжээг авна.

7.6. Нутгийн захиргааны байгууллага шаардлагатай тохиолдолд хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг агуулга, чиглэлээр нь багцлан хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн холбогдох арга хэмжээ авна.

Найм. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх:

8.1. Нутгийн захиргааны байгууллага энэ журмын 3.2.3-т заасан тайланг энэ журмын 10, 11, 12, 13, 14, 15 дугаар хавсралтын дагуу гаргаж, 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд харьяалах дээд шатны байгууллага, бүтцийн нэгжид хүргүүлнэ.

8.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь бодлогын хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагаанд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулна.

8.3. Сум, агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын шилэн дансны хөтлөлтийн нэгдсэн үнэлгээг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлнэ.

8.4. Сум, агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн үнэлгээг Төрийн архивын тасаг журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлнэ.

8.5. Хэрэглэгчийн үнэлгээ, шударга байдлын түвшний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлсэн дүнг ерөнхий үнэлгээнд оруулан тооцно.

8.6. Засгийн газрын тэргүүлэх чиглэлд орсон ажлын хэрэгжилтийг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу гаргаж ирүүлнэ. Тарьсан модны явцыг тодорхойлох, модны амьдралтын хувийг тогтоосон комиссын акт, хог хаягдлын зохицтой менежментийг хэрэгжүүлж буй ажил, цахим засаглалыг хэрэгжүүлэхэд гарч буй үр дүнгийн талаарх тайланг 14 дүгээр хавсралтын дагуу гаргаж, нотлох баримтын хамт 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд ирүүлнэ.

8.7. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын тэргүүлэх ач холбогдол бүхий чиглэлийн үнэлгээг энэ журмын 15 дугаар хавсралтын дагуу бодлогын хэлтэс нэгтгэж, аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлнэ.

8.8. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг тухайн зөвлөмжид заасан хугацаанд, хугацаа заагаагүй бол 8 дугаар хавсралтын дагуу гаргаж энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлнэ.

8.9. Орон нутгийн хөгжлийн сангийн үнэлгээг журмын 20 дугаар хавсралтын дагуу үнэлнэ.

Ес. Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан

9.1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээхэд аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (цаашид "цахим сан" гэх)-г ашиглана.

9.2. Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг ашиглах нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

9.3. Хэрэгжилтийн тайланг мэдээллийн цахим санд оруулахдаа тухайн зүйл, заалт, зорилт, арга хэмжээний хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах бөгөөд нотлох баримтыг файлаар заавал хавсаргана.

9.4. Мэдээллийн цахим санд мэдээлэл оруулж байгаа нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллага, албан тушаалтан мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна.

9.5. Аймгийн Засаг даргын Тамгын газар дор дурдсан асуудлыг хариуцна.

9.5.1. Мэдээллийн цахим сан, сүлжээний хэвийн, найдвартай ажиллагаа болон программ хангамж, системийн зохицуулалт, нэвтрэх эрх олгох асуудлыг зохицуулах;

9.5.2. Мэдээллийн цахим санд өөрт олгосон эрхийн дагуу хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ бүрийг хэрэгжүүлэх байгууллагатай холбох, тайлагнах хугацааг заах, холбогдох өөрчлөлтийг тухай бүр хийх;

9.5.3. Мэдээллийн цахим санд өөрт оногдсон эрхийн дагуу нэвтэрч, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

9.5.4. Мэдээллийн цахим сангийн үйл ажиллагаатай холбоотой сургалт, зааварчилгаа, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;

9.6. Нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллага дараах асуудлыг хариуцна.

9.6.1. Нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн болон тухайн асуудал хариуцсан ажилтан цахим санд нэвтэрч, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд оруулах;

9.6.2. Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ, тайланг сумдын Засаг даргын Тамгын газар, агентлаг, орон нутгийн өмчийн байгууллага удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний дараа цахим санд оруулан баталгаажуулж, холбогдох байгууллагад албан бичгээр хүргүүлэх;

9.6.3. Холбогдох байгууллагаас өгсөн үнэлгээтэй тухай бүр танилцаж, өгсөн удирдамж, зааврыг мөрдөн ажиллах;

9.6.4. Мэдээллийн цахим сан нь ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтэд зориулагдсан нээлттэй хэсэгтэй байна.

Арав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх:

10.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий үнэлгээгээр шалгарсан сумдын Засаг даргын Тамгын газрыг дараах шагналаар шагнаж урамшуулна.

10.1.1. Нэгдүгээр байр эзэлсэн сумыг Хүндэт өргөмжлөл, 12.0 сая төгрөг;

10.1.2. Хоёрдугаар байр эзэлсэн сумыг Хүндэт өргөмжлөл, 8.0 сая төгрөг;

10.1.3. Гуравдугаар байр эзэлсэн сумыг Хүндэт өргөмжлөл, 4.0 сая төгрөг;

10.1.4. Тусгай байр эзэлсэн 2 сумыг тус бүр Өргөмжлөл, 2.0 сая төгрөгөөр тус тус шагнаж урамшуулна.

10.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий үнэлгээгээр шалгарсан агентлагийг дараах шагналаар шагнаж урамшуулна.

10.2.1. Нэгдүгээр байр эзэлсэн агентлагийг Хүндэт өргөмжлөл, 8.0 сая төгрөг;

10.2.2. Хоёрдугаар байр эзэлсэн агентлагийг Хүндэт өргөмжлөл, 5.0 сая төгрөг;

10.2.3. Гуравдугаар байр эзэлсэн агентлагийг Хүндэт өргөмжлөл 3.0 сая төгрөг;

10.2.4. Тусгай байр эзэлсэн 2 агентлагийг тус бүр Өргөмжлөл, 1.0 сая төгрөгөөр тус тус шагнана.

10.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий үнэлгээгээр шалгарсан Засаг даргын Тамгын газрын хэлтсийг дараах шагналаар шагнана.

10.3.1. Нэгдүгээр байр эзэлсэн хэлтсийг Хүндэт өргөмжлөл, 3.0 сая төгрөг;

10.3.2. Хоёрдугаар байр эзэлсэн хэлтсийг Хүндэт өргөмжлөл, 2.0 сая төгрөг;

10.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий үнэлгээгээр шалгарсан Орон нутгийн өмчийн байгууллагыг дараах шагналаар шагнаж урамшуулна.

10.4.1. Нэгдүгээр байр эзэлсэн байгууллагыг Хүндэт өргөмжлөл, 5.0 сая төгрөг;

10.4.2. Хоёрдугаар байр эзэлсэн байгууллагыг Хүндэт өргөмжлөл, 3.0 сая төгрөг;

10.5. Жилийн ажлын үр дүнгээр тэргүүн байр эзэлсэн сумын Засаг дарга, агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын даргыг нэг сарын үндсэн цалин, дэд байр эзэлсэн сумын Засаг дарга, агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын даргыг нэг сарын үндсэн цалингийн 80 хувь, гуравдугаар байр эзэлсэн сумын Засаг дарга, агентлагийн даргыг нэг сарын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар шагнах асуудлыг аймгийн Засаг дарга шийдвэрлэнэ.

10.6. Журмын 10.1; 10.2; 10.3; 10.4-д заагдсан шагналыг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргана.

10.6. Аймгийн Засаг даргын Тамгын газар хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмж, дүгнэлтийн дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

10.6.1. Хэлтэс, агентлаг, сумдын тэргүүний арга, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийн хүртээл болгох, гарсан алдаа, дутагдлыг засах;

10.6.2. Нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

10.6.3. Нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар үүрэг, чиглэл өгөх, шаардлагатай тохиолдолд зохих удирдамжийн дагуу газар дээр нь хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах;

10.7. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь хяналт-шинжилгээ, үнэлгээг газар дээр нь хийх, хэрэглэгчийн болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, сургалт зохион байгуулах, сургалтын материал, ном, товхимол, гарын авлага хэвлүүлэх, мэдээллийн цахим сангийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зэрэг зардлыг өөрийн байгууллагын төсөвт жил бүр тусган батлуулна.

10.8.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, дүгнэлт, зөвлөмжид тулгуурлан тухайн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцан зохион байгуулна.

10.9. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хууль эрх зүйн асуудал эрхэлсэн хороо болон аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулна.

10.10. Хэлтэс, агентлаг, орон нутгийн өмчийн байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газрыг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

-100.00 хувь	“Үр дүнтэй”
-70.00 хувиас 100 хувь хүртэл	“Тодорхой үр дүнд хүрсэн”
-30.00 хувиас 70.00 хувь хүртэл	“Эрчимжүүлэх шаардлагатай”
-0.00 хувиас 30.00 хувь хүртэл	“Үр дүнгүй”

Арван нэг. Хариуцлага

11.1.Тухайн жилдээ ажлын үзүүлэлтээр “Эрчимжүүлэх шаардлагатай”, “Үр дүнгүй” үнэлгээ авсан аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, Агентлагийн дарга, сумын Засаг дарга, Орон нутгийн өмчийн байгууллагын даргын мэдээллийг

аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

11.2.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүнгээр хоёр удаа үнэлгээ буурсан, 50 хувиас доош үнэлгээ авсан сумын Засаг дарга, Агентлаг, Орон нутгийн өмчийн байгууллагын удирдлагад Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн дагуу аймгийн Засаг дарга хариуцлага ногдуулна.

11.3.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүнгээр хоёр удаа хангалтгүй үнэлгээ авсан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт нь буурсан сум, агентлагийн холбогдох албан тушаалтныг Төрийн албаны тухай хуулийн 45.1-д заасны дагуу албан тушаал бууруулах саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжилна.

11.4. Дараах зөрчил гаргасан сумдын Засаг дарга, агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын захирал, дарга нарт Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн болон холбогдох бусад хуульд зааснаар дараах хариуцлагыг аймгийн Засаг дарга хүлээлгэнэ.

11.4.1.Энэхүү журмын 3 дахь бүлэгт тусгагдсан хяналт шинжилгээ, үнэлгээний зарчим, хамрах хүрээг зөрчиж худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан;

11.4.2. Ажлын үнэлгээтэй холбогдуулан өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй, гаргасан зөрчил, дутагдлаа дахин давтсан;

11.4.3. Биелэлтийг тайлагнахдаа тухайн байгууллагын удирдлага, гарын үсэг зурж, баталгаажуулаагүй;

11.4.4. Тогтоосон хугацаанд үнэлгээ хийж ирүүлээгүй, цахим болон цаасан тайланг хугацаа хоцроосон, тайлан бичих, үнэлгээ хийх ажилд хайнга хандсан;

11.5.Босоо удирдлагатай байгууллагын дарга нарт арга хэмжээ авах саналыг дээд удирдлагад нь уламжилж шийдвэрлүүлэх;

11.6.Төсвийн шууд захирагч нар 11.4 дэх заалтыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

Журмын 1 дүгээр, хавсралт

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ЦАГЛАВАР



д/д	Тайлангийн төрөл	Тайллагнах хугацаа			
		Сумын Засаг даргын Тамгын газар (ТЗУХ -т тайлагнах)	Агентлаг (харьяа бодлогын хэлтэст)	Бодлогын хэлтэс (ТЗУХ -т тайлагнах)	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ХШҮХ -т тайллагнах)
1	2	3	4	5	6
Бодлогын баримт бичиг					
1	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого“Алсын хараа-2050”	-	VII/20	VIII/01	VIII/15 (тэгш онд)
2	Хөгжлийн зорилтот хөтөлбөр	VI/20	VI/20	VII/01	VII/15
3	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	-	XI/20	XII/01	XII/10
4	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хамт)	-	XI/20 V/20 Сар бүрийн 25 - ны дотор цахим системээр	Нэгдсэн тайлан: XII/01 VI/01 Сар бүрийн 01- ний дотор цахим системээр	Нэгдсэн тайлан: XII/10 VI/15 Сар бүрийн 01-ний дотор цахим системээр
5	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	-	XI/20 V/15 Сар бүрийн 25 - ны дотор цахим системээр	Нэгдсэн тайлан: XII/01 V/25 Сар бүрийн 01- ний дотор цахим системээр	Нэгдсэн тайлан: XII/10 VI/05 Сар бүрийн 01-ний дотор цахим системээр

1	2	3	4	5	6
6	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	-	I/05	I/20	II/10
7	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хамт)	XII/20 V/20 Сар бүрийн 25 -ны дотор цахим системээр	XII/20 V/20 Сар бүрийн 25 -ны дотор цахим системээр	Нэгдсэн тайлан: I/01 VI/01 Сар бүрийн 01-ний дотор цахим системээр	Нэгдсэн тайлан: I/10 VI/15 Сар бүрийн 01-ний дотор цахим системээр
8	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө	XI/20 V/15 Сар бүрийн 25 -ны дотор цахим системээр	XI/20 V/15 Сар бүрийн 25 -ны дотор цахим системээр	Нэгдсэн тайлан: XII/01 V/25 Сар бүрийн 01-ний дотор цахим системээр	Нэгдсэн тайлан: XII/10 VI/05 Сар бүрийн 01-ний дотор цахим системээр
9	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хамт)	XI/20 V/15			Нэгдсэн тайлан: XII/10 VI/05
10	Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө	XI/20 V/15	XI/20 V/15	Нэгдсэн тайлан: XII/01 V/25	Нэгдсэн тайлан: XII/10 VI/05
11	Хуульд нийцүүлэн хүчингүй болсонд тооцсон болон хугацаа дууссан бодлогын баримт бичгийн тайлан	-	VI/01 XII/01	VI/10 XII/10	VI/20 XII/20
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт					
12	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр	XII/30 V/30	XII/30 V/30	I/10 VI/15	I/25 VI/25

1	2	3	4	5	6
13	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолын хэрэгжилт	XII/30 V/30	XII/30 V/30	I/10 VI/15	I/25 VI/25
14	Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Засаг даргын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт	XII/30 V/30	XII/30 V/30	I/10 VI/15	I/25 VI/25
15	Хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт	VII/10 XII/30	VII/10 XII/30	VII/20 I/05	XII/10 VI/20
Төсөл					
16	Гадаадын зээл, тусlamжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	I/20	I/20	II/01	II/15
Байгууллагын үйл ажиллагаа					
17	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт	XII/30	XII/30	I/05	I/10
18	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	VII/10 XII/30	VII/10 XII/30	VII/20 I/05	VII/20 I/10
19	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт	VII/10 XII/30	VII/10 XII/30	VII/20 I/05	II/10
20	Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	VII/10 XII/30	VII/10 XII/30	VII/20 I/05	II/10
21	Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлэн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт		VII/10 XII/30	VII/20 I/05	XII/10 VI/20
22	Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт	VII/10 XII/30	VII/10 XII/30	VII/20 I/05	XII/10 VI/20
23	Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт	VII/10 XII/30	VII/10 XII/30	VII/20 I/05	XII/10 VI/20
24	Агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээ		VII/10 XII/30	VII/20 I/05	XII/10 VI/20

1	2	3	4	5	6
25	Тухайн жилд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт	VII/10 XII/30	VII/10 XII/30	VII/20 I/05	XII/10 VI/20
26	Шилэн данс хөтлөлтийн үнэлгээ				VII/20 I/20 Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс ХШҮХ-т
27	Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ				VII/01 XII/25 Архивын тасаг ХШҮХ-т

.....ооо.....

Журмын 2 дугаар хавсралт

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)
				Он	Түвшин		

Бодлогын баримт бичгийн зорилго 1

1.	Зорилт 1						
1.1.	Арга хэмжээ						
1.2.	Арга хэмжээ						
1.3.	Арга хэмжээ						

Бодлогын баримт бичгийн зорилго 2

2.	Зорилт 2						
2.1.	Арга хэмжээ						
2.2.	Арга хэмжээ						
2.3.	Арга хэмжээ						

.....оо.....

Журмын 3 дугаар хавсралт



УРТ, ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ЗАГВАР

д/д	Үйл ажиллагаа	Санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
			Бүлгийн нэр 1.....	
			Зорилго.....	
			Зорилт.....	
	Үйл ажиллагаа 1..			
	Үйл ажиллагаа 2..		Бүлгийн нэр 1.....	
			Зорилго.....	
			Зорилт.....	
	Үйл ажиллагаа 1..			
	Үйл ажиллагаа 2..			

.....оо.....

Журмын 4 дүгээр хавсралт



...ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (...ОН)

д/д	ХБТББ-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилт ийн явц	Хэрэгжилтийн хувь		
								Он						
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13		
ХӨГЖЛИЙН САЛБАР №1.1.														

.....оо.....

Журмын 5 дугаар хавсралт



... ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ,
ЗОРИЛТОТ ТҮВШИНГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (..... ОН)

Дугаар	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Бүлгийн нэр							

.....ооо.....

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр тодорхойлсон үр нөлөө

A. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөлөл

<p>1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр нөлөө үзүүлсэн зорилтот бүлэг болон бусад бүлэг</p> <p>2. Эдийн засгийн хөгжил болон захиргааны үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөө</p> <p>3. Бусад мэдээлэл</p>	<p>Бодлогыг хэрэгжүүлснээр хууль ёсны эрх ашиг, санхүүгийн боломж, өнөөгийн нөхцөл байдалд нь шууд болон шууд бусаар нөлөөлсөн нийгмийн зорилтот бүлгийг тодорхойлно. Зорилтот бүлэг гэж бүлэг хувь хүмүүс, нийгмийн бүлэг, байгууллага (Засгийн газрын болон орон нутгийн удирдлагын байгууллага, түүний ажилчид) зэрэг тухайн бодлогыг хэрэгжүүлснээр зерэг болон сөрөг нөлөөнд өртсөн бүлгийг хэлнэ.</p> <p>1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын шалгуур үзүүлэлтэд үзүүлсэн нөлөөллийг тодорхойлох</p> <p>2. Захиргааны үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөллийг тооцоолох:</p> <p>2.1. захиргааны үйл ажиллагааны нөлөө хэвээр үлдсэн бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилтот бүлгийн эрх ашиг, хариуцлагыг хөндөөгүй гэдгийг тодорхойлон бичих;</p> <p>2.2. захиргааны үйл ажиллагааны нөлөө буурч байгаа бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс үр шим хүртэж байгаа нийгмийн бүлэг, байгууллага, аж ахуй, салбарыг тодорхойлон бичих;</p> <p>2.3. захиргааны үйл ажиллагааны нөлөө нэмэгдэж байгаа бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь нийгмийн ямар бүлэг, байгууллага, аж ахуй, салбарт үзүүлж байгаа ямар гол өөрчлөлтүүд бий болж байгааг тодорхойлон бичих.</p> <p>Энэхүү үр нөлөөний үнэлгээний "A"-гийн 1, 2 дахь хэсэгт дурдаагүй эдийн засгийн хөгжилд үзүүлсэн нөлөөллийн талаар энд бичиж болно.</p>
<p>B. Хөгжлийн бодлогын баримт бичгийн нийгмийн хөгжилд үзүүлсэн нөлөөлөл</p> <p>1. Хэрэв тухайн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлснээр нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн бол тухайн бүлэгт үзүүлсэн үр нөлөөг тодорхойлно. Үр нөлөөг тодорхойлоходоо тухайн бүлэгт үзүүлсэн нөлөөллийн хэмжээ, нөлөөлсөн магадлал, үр дүнгийн талаар байна. Тухайлбал, орон нутгийн захиргааны байгууллага, Засгийн газар, жижиг, дунд, том бизнес эрхлэгчид, импортлогчид, экспортлогчид, дотоодын зах зээлд бүтээгдэхүүн ханган нийлүүлэгчид, хэрэглэгчид, газар зүйн бусууд, нийгмийн бүлгүүд байна.</p> <p>Нийгэмд үзүүлсэн нөлөөлөл нь түр зуурын байх, эсхүл урт хугацааны байх гэдгийг тодорхойлно.</p> <p>2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр ямар нөлөө үзүүлэхийг дараах байдлаар тодорхойлсон байна:</p> <p>2.1. хүмүүсийн амьдралын хэв маягт үзүүлсэн нөлөөний талаар;</p> <p>2.2. хүмүүсийн соёлд ямар нөлөө үзүүлсэн (хамтын итгэл, зан үйл, үнэт зүйл, соёл гэх мэт);</p> <p>2.3. хүмүүсийн амьдардаг суурин болон нийгмийн бүлэгт ямар нөлөө үзүүлсэн (уялдаа, тогтвортой байдал, шинж чанар, үйлчилгээ, байгууламж);</p>	

2.4. хүрээлэн буй орчинд ямар нөлөө үзүүлсэн (хүмүүсийн хэрэглэдэг ус, амьсгалдаг агаарын чанар, хүнсний бүтээгдэхүүний чанар, олдоц, аюул, эрсдэлийн түвшин, тоос, дуу чимээний хэмжээ, ариун цэврийн байгууламжийн хангамж, байгууламжийн аюулгүй байдал, нөөцөөс хүртэх боломж, нөөцөд хяналт тавих боломж).

3. Бусад мэдээлэл	Энэхүү нөлөөллийн үнэлгээний "Б"-гийн 1, 2 дахь хэсэгт дурдаагүй нийгмийн хөгжилд үзүүлсэн нөлөөллийн талаар энд бичиж болно.
В. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлсэн нөлөө	
1. Бодлогыг хэрэгжүүлэх явцад бий болсон хууль, эрх зүйн шинэчлэл	Тухайн бодлогыг хэрэгжүүлэх явцад өөрчлөлт, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулсан, батлагдсан хууль тогтоомж, дүрэм, журмуудыг жагсаан бичнэ.
Г. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын (институцийн) тогтолцоонд үзүүлсэн нөлөө	
1. Төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд үзүүлсэн нөлөө	1. Бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор хэрэв териийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд өөрчлөлт оруулсан бол энэ хэсэгт өөрчлөлтүүдийг оруулна. (шинээр бий болсон бүтэц, өнөөгийн институцийг татан буулгасан, эсхүл бүтцийг өөрчилсөн байгуулах)
2. Хүний нөөцөд үзүүлсэн нөлөө	Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын хүний нөөц, чадавхид гарсан бол өөрчлөлтийг бичнэ.

.....оо.....

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удаширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
Монгол Улсын хууль					
Хэсгийн дундаж: ... хувь					
Улсын Их Хурлын тогтоол					
Хэсгийн дундаж: ... хувь					
Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол					
Хэсгийн дундаж: ... хувь					
Ерөнхийлөгчийн зарлиг					
Хэсгийн дундаж: ... хувь					
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зэвлөмж, тэмдэглэл					
Хэсгийн дундаж: ... хувь					
Засгийн газрын тогтоол					
Хэсгийн дундаж: ... хувь					
Ерөнхий сайдын захирамж					
Хэсгийн дундаж: ... хувь					
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
Хэсгийн дундаж: ... хувь					
Засгийн газрын албан даалгавар					

Хэсгийн дундаж: хувь

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол

Хэсгийн дундаж: хувь						

Аймгийн Засаг даргын захирамж

Хэсгийн дундаж: хувь						

Аймгийн Засаг даргын албан даалгавар

Хэсгийн дундаж: хувь						

Засаг даргын зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт
--

Хэсгийн дундаж: хувь						

Нийт дундаж: хувь

.....оо.....

Журмын 8 дугаар хавсралт

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГЭЭР
ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	Зөвлөмжийн заалт	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь

.....ооо.....

Журмын 9 дүгээр хавсралт

ДЭД ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
ТАЙЛАГНАХ ЗАГВАР

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/
Нэг. “.....” зорилтын хүрээнд					
1.1	Арга хэмжээ				Хүрсэн түвшин буюу арга хэмжээний хэрэгжилтийг бичнэ Хэрэгжилтийн хувь
1.2	Арга хэмжээ				Хүрсэн түвшин буюу арга хэмжээний хэрэгжилтийг бичнэ. Хэрэгжилтийн хувь

.....оо.....

Журмын 10 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ
ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 20... ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ
ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ЗАГВАР

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/
Нэг. "....." гэрээний заалтын хүрээнд					
1.1	Арга хэмжээ				Хүрсэн түвшин буюу арга хэмжээний хэрэгжилтийг бичнэ Хэрэгжилтийн хувь
1.2	Арга хэмжээ				Хүрсэн түвшин буюу арга хэмжээний хэрэгжилтийг бичнэ. Хэрэгжилтийн хувь

.....оо.....

Журмын 11 дүгээр хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ-ЫН
20... ОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ЗАГВАР

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/
1	2	3	4	5	6
Нэг. "....." гэрээний заалтын хүрээнд					
1.1	Арга хэмжээ				Хүрсэн түвшин буюу арга хэмжээний хэрэгжилтийг бичнэ Хэрэгжилтийн хувь
1.2	Арга хэмжээ				Хүрсэн түвшин буюу арга хэмжээний хэрэгжилтийг бичнэ. Хэрэгжилтийн хувь

.....оо.....

Журмын 12 дугаар хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ,
АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (..... он)

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
1	2	3	4	5	6	7

Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх

1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Үүнээс	1.1. Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	-		
			Ажлын байран дахь сургалт	-		
			Мэргэшүүлэх сургалт	-		
			Туршилаа солилцох арга хэмжээ	-		
			Бусад	-		
		Үүнээс	1.2. Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-		
			Эмэгтэй албан хаагч	-		1. Нэг удаагийн сургалтын хугацаа 4 цагаас дээш бол тайлагнана.
			Эрэгтэй албан хаагч	-		
			Удирдах албан тушаалтан	-		2. Зорилтот түвшин хэсэгт байгууллагын сургалтын төлөвлөгөөнд туссан дунг бичнэ.
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-		
		Үүнээс	1.3. Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш		3. Гадаад улс орон, хилийн чанадад хамрагдсан сургалтыг тайлагнана.
			Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-		
			Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-		4. Дэлгэрэнгүй судалгаа мэдээллийг тайландаа хавсаргасан байна.
			Эмэгтэй албан хаагч	-		
			Эрэгтэй албан хаагч	-		
		Үүнээс	Удирдах албан тушаалтан	-		
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-		
			Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш		
			Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт			
			3.1. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан			Тайлант оны гүйцэтгэлээр

1	2	3	4	5	6	7
	зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош		Тайлант оны гүйцэтгэлээр
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	-		Тайлант оны гүйцэтгэлээр
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	-		Хоногт олгохоор тогтоосон дүн
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш		Асуулгын агуулга, хэлбэр нь жишиг загварт нийцсэн байна
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх узлэг (Жилд)	1-ээс дээш		Төрөлжсөн болон багц шинжилгээ
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш		Сайн дураар хамрагдах
